



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 11 өдөр

Дугаар А/03

Шивээговь сум

Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн
бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар
шилжүүлсэн хугацааг сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 в, 29.1.6.а, 29.1.6.б, 29.1.6.ж, 29.1.6.л, 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2, 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.1, 32 дугаар зүйлийн 32.1.1, Засгийн газрын 2020 оны 238 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын 2020 оны 40 дүгээр хурлын тэмдэглэл, аймгийн Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн А/03 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацааг 2021 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 24:00 цаг хүртэл сунгасугай.

2. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацааг сунгасантай холбогдуулан хэнсний дэлгүүр, супермаркетууд, сул агууламжтай согтууруулах ундаа худалдан борлуулах, түүгээр үйлчилдэг аж ахуйн нэгж, байгууллага, бүх төрлийн нийтийн хоолны үйлдвэрлэл, үйлчилгээ /ресторан, зоогийн газар, кафе/-ний газрууд, бариа заслын үйлчилгээг халдвар хамгааллын дэглэм, тусгай нөхцөл шаардлагыг хангасны үндсэн дээр 09:00-22:00 цагийн хооронд ажиллуулахыг зөвшөөрсүгэй.


3. Зайлшгүй шаардлагатайгаас бусад тохиолдолд аймаг, хот хооронд хувийн тээврийн хэрэгслээр зорчихыг хязгаарлах, халдвар хамгааллын дэглэмийг сахиулан батлагдсан зам, маршрутаар хөдөлгөөнд оролцуулах, бүртгэлжүүлэн ажиллахыг сумын Цагдаагийн хэсгийн дарга, цагдаагийн хошууч /Б.Шинэбаяр/,

421210020

Мал эмнэлгийн тасгийн Улсын байцаагч /Ш.Буяаннэмэх/ нарт тус тус үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч, Онцгой комиссын орлогч дарга /Ч.Сугармаа/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ